



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/491

Булган сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн “Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд нийгмийн амьдралд оролцох, эвлэлдэн нэгдэх, хүүхдийн эрхийг хангах аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцох, өөрсдийн санал бодлоо илэрхийлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэн, эрсдэлт нөхцөлийн болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуслангийн хөгжлийн хөтөлбөрт тэгш хамруулах зорилгоор Дархан-Уул аймгийн Зулзагын гол хүүхдийн зусланд зохион байгуулагдах бүсчилсэн арга хэмжээнд орон нутгаас оролцох хүүхдүүдийг зохион байгуулалтаар ханган оролцуулсугай.

2. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт оролцох хүүхдүүдэд шаардагдах 2,498,640 (хоёр сая дөрвөн зуун ерэн найман мянга зургаан зуун дөх) төгрөгийг аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүүхэд хамгаалал”-ыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас 2,261,360 (хоёр сая хоёр зуун жаран нэгэн мянга гурван зуун жар) төгрөгийг “Шинэ ирээдүй” хөтөлбөр төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Тус арга хэмжээнд оролцогч хүүхдүүдийн аюулгүй байдалд анхаарч, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Т.Баярбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Desk-toot/zahiramj

6323010490

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын
15 өдрийн А/НЭД Дугаар захирамжийн хавсралт

ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮДИЙГ ЗУСЛАНГИЙН ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨРТ ТЭГШ ХАМРУУЛАХ БҮСЧИЛСЭН АРГА ХЭМЖЭЭНД
ОРОЛЦОГЧДОД ШААРДАГДАХ ТӨСӨВ

| № | Шаардагдах зардал | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|--|---|-------------------|----------------------------|-----------------------------------|
| 1. | Хувцас жигдрэлт: - Малгай - Футьволк - Бүч | 68ш 68ш 68ш | 25,000 35,000 10,000 | 1,700,000 2,380,000 680,000 |
| Нийт дүн | | | 4,760,000 | |
| Үүнээс: | | | | |
| - 2,498,640 (хоёр сая дөрвөн зуун ерэн найман мянга зургаан зуун дөч) төгрөгийг аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүүхэд хамгаалал”-ыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас | | | | |
| - 2,261,360 (хоёр сая хоёр зуун жаран нэгэн мянга гурван зуун жар) төгрөгийг “Шинэ ирээдүй” хөтөлбөр төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас | | | | |

-----oO-----